

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**
(Бодлогын судалгаа)

Ц. Төвүүсүрэн, Т. Мягмаржав

АГУУЛГА

Нэг. Судалгааны зорилго

Хоёр. Нийгмийн халамжийн тогтолцооны үзэл баримтлалын онолын үндэслэл, бусад орнуудын туршлага

- 2.1. Нийгмийн халамжийн тогтолцооны онолын үндэслэл, үзэл баримтлалын харьцуулалт
- 2.2. Нийгмийн халамжийн хуулиудын үзэл баримтлал, тогтолцооны ялгаа, давуу болон сул талууд
- 2.3. Нийгмийн халамжийн үйлчилгээний эрх зүйн орчны талаархи бусад орнуудын туршлага /харьцуулалт/

Гурав. Нийгмийн халамжийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагаа

- 3.1. Нийгмийн халамжийн салбарын бодлогын тодорхойлж буй баримт бичгүү
- 3.2. Нийгмийн халамжийн харилцааг зохицуулж буй Монгол улсын хуулиуд
- 3.3. Нийгмийн халамжийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд

Дөрөв. “Нийгмийн халамжийн тухай” хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ

- 4.1. Нийгмийн халамжийн байгууллагын үнэлгээ, санал дүгнэлт
- 4.2. Төрийн бус байгууллагуудын үнэлгээ санал дүгнэлт

Тав. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн шинжилгээ

- 5.1. Улсын төсвийн нийт зардалд халамжийн зардлын эзэлж буй хувийн динамик судалгаа
- 5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого зарлагын судалгаа
- 5.3. Нийгмийн халамжийн сангаас олгосон халамж үйлчилгээний судалгаа

Зургаа. “Нийгмийн халамжийн хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” судалгааны санал, дүгнэлт, зөвлөмж

* * *

ТАНИЛЦУУЛГА

Нэг. Судалгааны зорилго нь:

Нийгмийн халамжийн тогтолцооны үзэл баримтлал, онолын үндэслэл, харилцааг зохицуулж буй хуулийн хэрэгжилт, нийгмийн халамжийн харилцаа бусад орнуудын хувьд хэрхэн зохицуулагдаж байгааг шинжлэн судлахад оршино.

Судалгааны явцад:

- “Нийгмийн халамжийн тухай” хуулиар зохицуулж буй харилцаа, гадаад орнуудын туршлага, /харьцуулсан судалгаа/
- Нийгмийн халамжийн байгууллагын болон ТББ байгууллагуудын өгсөн үнэлгээ, санал дүгнэлтийг нэгтгэн дүгнэх
- Нийгмийн халамжийн үйлчилгээний судалгаа болон хуулиудын хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх зэрэг зорилт тавьсан болно.

1.2. Судалгааны арга зүй

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн судалгааг хийхдээ бодлогын хэд хэдэн судалгааны аргыг хэрэглэсэн болно. Үүнд:

- Нэгд. Нийгмийн халамжийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагаа, албан ёсны бичиг баримт /тайлан, статистик мэдээлэл, судалгаа гэх мэт/ -д анализ хийх
- Хоёрт. Хэрэгжилт зохицуулалт механизмын талаар төрийн албан хаагчид, халамжийн мэргэжилтнүүдийн төлөөллөөс мэдээлэл авах
- Гуравт. Судалгааг онолын үндэслэл, олон улсын жишгийг үндэс болгон харьцуулсан шинжилгээний аргаар гүйцэтгэх

1.3. Судалгааны ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

- Нийгмийн халамжийн харилцаатай холбоотой бичиг баримтад дүн шинжилгээ хийсэн
- Гадаад орнуудын туршлагыг судалж харьцуулалт хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, тайлан бичсэн

Хоёр. Нийгмийн халамжийн тогтолцооны үзэл баримтлалын онолын үндэслэл, бусад орнуудын туршлага

2.1. Нийгмийн халамжийн тогтолцооны онолын үндэслэл, үзэл баримтлалын харьцуулалт

Манай улсад анх 1995 онд Нийгмийн халамжийн багц хууль батлагдан мөрдөгдөж байгаад 2005 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталснаас хойш түүнийг мөрдөн ажиллаж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ манайд дор дурдсан чиглэлийг хамарч байна:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тэтгэвэрт нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах болзлыг хангаагүй, орлогогүй иргэдийг хамруулах бөгөөд 2006 оноос хүрээ нь өргөжиж хүүхэд бүрт тэтгэмж олгох, шинэ гэр бүлд мөнгөн тусламж олгох зэргээр анхныхаа үзэл баримтлалаас хазайсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр нь тухайн иргэнийг асарч халамжлах хүнгүй, амьдралын хүнд нөхцөлд орсон тохиолдолд улсын төсвөөс олгож байгаа мөнгөн тусламж юм. Нийгмийн халамжийн тэтгэвэр дараахь төрөлтэй байна:

- Ахмад настны халамжийн тэтгэвэр
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр

- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/ -ийн халамжийн тэтгэвэр
- Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр

Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ нь Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуу амьдралтай айл өрхөд мөнгөн тэтгэмж олгох, орон сууцны хөлс, түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлэх, рашаан сувилалд амруулах, хиймэл эрхтэн хийлгэх зэрэг зарим төрлийн нөхөн төлбөр олгох арга хэмжээг хамруулдаг. Эдгээр хөнгөлөлтөд ядуу амьдралтай хүнд нөхцөлд байгаа иргэдээс гадна төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмадууд, ардын болон гавъяат цолтон, дайн тулалдаанд оролцогчид хамрагддаг. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж нь дор дурдсан төрөлтэй байна:

- Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж,
- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж
- Бүтэн өнчин, эцэг эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмчлүүлж байгаа, хорих газар ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхэд (Гэр бүлийн тухай хуулийн 25.5) болон хүчирхийллийн улмаас бие мах бодийн хохирол хүлээж, хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж
- Ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн жилийн амьжиргааны доод түвшинг харгалзан Засгийн газар тогтоож байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж нь дараахь төрөлтэй байна:

- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж /3 хүртэл насны ихэр хүүхдэд жилд нэг удаа, байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа, 3 ба түүнээс дээш бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх/эцэг/-д жилд нэг удаа, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд жилд 1 удаа, гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад дэмжлэг үзүүлж 1 удаа/
- Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт
- Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт
- Протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хангамж
- Сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт
- Эх орны рашаан сувилалын зардлын хөнгөлөлт
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд нийгмийн халамжийн хөнгөлөлт, тусламж олгохоор заасан дээрхи иргэдэд амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, зохион байгуулалттай хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, энэ чиглэлээр төсөл хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах, сэргээн засах үйлчилгээнд хамруулах, түр байрлуулан асрамжлах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах зэргийг хамааруулан ойлгож болно.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие эсхүл тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан, мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүнд нөхцөлд байгаа, эсхүл байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэл насны хүүхэд, гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд хамрагдана.

Эдгээрээс гадна хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ гэр бүлийн мөнгөн тэтгэмж, шинээр мэндэлсэн хүүхдийн мөнгөн тусламж, хүүхдийн хөгжлийн мөнгөн тусламж зэрэг сонгуулийн амлалтаар буй болсон тэтгэмжүүд ч нийгмийн халамжийн үйлчилгээнд хамаарах бөгөөд эдгээрийн хэмжээ нь 146,6 тэрбум төгрөгт хүрч нийт халамжийн сангийн зарцуулалтын 69 % -ийг эзэлж байна.

Хүн амын нийгмийн хамгааллын тогтолцооны салшгүй нэг хэсэг бол нийгмийн халамжийн асуудал юм. Нийгмийн амьдралын нугачаанд тулгарсан хүндрэл бэрхшээлтэй тэмцэх чадваргүй, өөрт тохиолдсон эрсдлээс даатгалын тогтолцоогоор дамжуулан хамгаалагдах нөхцөл болзлыг хангаж чадаагүй хэсэг бүлэг хүмүүс аль ч нийгмийн үед, хөгжлийн ямар ч түвшинд байсаар ирсэн, цаашид ч байх болно. Эдгээр хүмүүст хүмүүнлэг ардчилсан нийгмийн гишүүн болохынх нь хувьд амьдрах боломж олгох, дэмжиж туслах шаардлага зайлшгүй тавигддаг.

Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх арга хэрэгслийн нэг нь нийгмийн халамжийн тогтолцоо юм. “Нийгмийн халамж гэдэг нь амьдралд тохиолдсон хүндрэл бэрхшээлийн үед бие даан амьрах чадвар сул, эрсдэлд өртөмтгий хүмүүсийн амьжиргааны нөхцлийг дээшлүүлэхэд нийгмээс материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэх, дадал туршлагыг нь дэмжих, амьдралын итгэл үнэмшил олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа” гэж доктор Ч. Дагвадорж тодорхойлжээ.

Үүнийг нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах нөхцөл болзлыг хангаагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд, олон хүүхэдтэй бэлэвсэрсэн орлогогүй гэр бүлд амьдралын бололцоо олгоход чиглэсэн дэмжиж туслах, асрамжлах, халамжлах үйлчилгээг төр, байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүсийн зүгээс үзүүлэх үйл ажиллагаа гэж ойлгож болно. “Нийгмийн халамж нь үндсэн гурван субьектив хүчин зүйлээр нөхцөлдөж, гурван объектыг хамарч, гурван төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг” гэж доктор . Дагвадорж томъёолжээ.

Нийгмийн халамжийн субьектив хүчин зүйлүүд. Нийгмийн эмзэг хэсгийн хүн амд халамжийн үйлчилгээ үзүүлэхэд төрийн тэтгэлэг, аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэг тусалцаа, иргэд хувь хүмүүсийн хувь нэмэр гэсэн гурван субьектив хүчин зүйлийн зорилго, чиглэл, хөрөнгө хүчийг нэгтгэснээр үр дүн нь дээшилдэг. Төрөөс нийгмийн халамжийн эрх зүйн үндэс, хамрах хүрээ, хэлбэр, нэр төрөл хүртээмж, арга механизмыг тогтоож, түүнийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийг үндэсний орлогын дахин хуваарилалтаар бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

Өндөр хөгжилтэй АНУ, Япон, Герман болон хөгжиж буй Тайланд, Сингапур, Индонез зэрэг орнуудын компани байгууллага, хувь хүмүүсийн оролцоо нийгмийн халамжийн үйл ажиллагаанд ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. АНУ-д нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст олгох, тэтгэвэр, тэтгэмжийг төр захиргааны байгууллага хариуцаж, тэднийг хооллох, байрлуулах, зэрэг асрамж, халамжийн үйлчилгээг буяны болон төрийн бус байгууллага гүйцэтгэдэг бол Японд асрамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлж байна.

Нийгмийн халамжийн хамрах хүрээ. Аль ч улс оронд халамжийн үйлчилгээнд нэн тэргүүн

ээлжинд хамрагддаг гурван хүрээ байдаг.

1. Асран хамгаалах хүнгүй өнчин хүүхдүүд халамж асрамжийн үйлчилгээнд эхний ээлжинд хамрагддаг байна.
2. Хөдөлмөр эрхлэх чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг халамжийн үйлчилгээнд хамруулдаг. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалгуурыг зөв нарийн тогтоохгүй бол халамжинд хамруулах хүрээг өргөжүүлэх үүд хаалгыг нээхэд хүрдэг.
3. Бие даан амьдрах чадваргүй, халамжлах, дэмжих үр хүүхэдгүй, асран хамгаалагчгүй ахмад настнууд халамжийн үйлчилгээнд хамрагдах ёстой.

Зарим цөөнгүй улс оронд зөвхөн 60, 65 нас хүрсэн, сэтгэцийн гажигтай, архаг өвчтэй, хараагүй, дүлий, хөдөлгөөний дутагдалтай, асрах хань ижил, үр хүүхэдгүй, хөдөлмөр эрхлэх боломжгүй, өөрийгөө авч явах чадваргүй, бага орлоготой, ядуу амьдралтай ахмад настанд нийгмийн зүгээс халамж, дэмжлэг үзүүлдэг байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд бага орлоготой, ядуу амьдралтай, бэлэвсэрсэн хүмүүс, орох орон гэргүй хүмүүс гэх мэтчилэн олон янзын хүмүүсийг хамруулдаг ч тухайн оронд хэрэгжиж байгаа нийгмийн хамгааллын үзэл баримтлал, арга хэлбэр, хууль тогтоомжийн дагуу л шийдвэрлэгддэг.

Халамжийн үйлчилгээний төрлүүд: Нийгмийн халамжийн үйлчилгээг дэмжлэг тусламж үзүүлэх, асрамжийн болон халамжийн үйлчилгээ гэж 3 ангилж болох юм.

1. Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн төрөлд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор, буцалтгүй тусламж олгох замаар тэдэнд тохиолдсон цаг зуурын эрсдлийг зөөлрүүлэх үйл ажиллагаа багтана. Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг тэдгээрийн зориулалт, хамрах хүрээ, сонголт, давхардлаас шалтгаалан буцалтгүй, олон удаагийн, тасралтгүй, бөөнөөр болон хэсэгчилсэн гэж ангилж болно. Ихэвчлэн өндөр наслах, тахир дутуу болох, хүүхэд төрүүлэх, асрах, үрчлэн авах, халамжлахад улсаас тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нөхөн төлбөр олгодог. Харин өглөг буяны шугамаар дэмжлэг тусламжаа үзүүлэхэд төрийн бус байгууллагууд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэдэг.
2. Асрамжийн үйл ажиллагаа нь бие даан амьдрах чадваргүй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, байнгын эмчилгээ үйлчилгээ шаардагдах иргэд, өнчин хүүхдийг байнга байрлуулах, хоол, хувцас, хэрэглэл, эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээгээр хангах, тэдний амьдралын хэвийн нөхцөл, хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чиглэгдэнэ.
3. Халамжийн үйлчилгээнд амьдралын түр зуурын эрсдэлд өртсөн иргэдийг хооллох, усанд оруулах, хувцаслах, ариун цэврийн үйлчилгээ үзүүлэх, эд материалын зүйлээр туслахаас гадна сэтгэл санааны дэм үзүүлэх, эмчлэх, сувилах, амьдралын урам зориг нэмэх, итгэл үнэмшил төрүүлэх, амьдрах ухааны дадал эзэмшүүлэх, бие даан амьдрахад нь туслахад чиглэгдсэн үйл ажиллагаанууд хамаарна.

2.2. Улс орнуудын нийгмийн халамжийн хуулиудын үзэл баримтлалын ялгаа, давуу болон сул талууд

Судалгаанд хамрагдсан орнуудын нийгмийн халамжийн төрөл, түүнд хамруулсан хүн амын бүлэг хэсгийн хувьд харилцан адилгүй байгаа боловч ихэнх улс орнуудад нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж авах эрх үүсээгүй, хүнд нөхцөлд амьдардаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн тийм хүүхдийг нийтлэг хамруулсан байна. Энэхүү судалгааны харьцуулалтад хамруулаагүй ОХУ-ын хувьд нийгмийн халамжийн үйл ажиллагааг Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээний тухай болон Нийгмийн дэмжлэгийн тухай хуулиудаар зохицуулсан бөгөөд ОХУ-ын субъект /Москва хот/ тус

тусын хуулиар нарийвчлан зохицуулж байна.

Москва хотын нийгмийн дэмжлэгийн тухай хуулиар дээрхи орнуудын нэгэн адил ядуу амьдралтай ахмад настан, ганц бие ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүнд амьдралтай хүүхдүүдийг хамруулаад зогсохгүй эх орны дайны ахмад дайчид, хэлмэгдэгсэд, Карибын хямрал, Чернобылийн атомын станцын сүйрэл, цацрагийн хордлогод нэрвэгдсэн иргэд, Маяк үйлдвэрийн осолд өртөгсөд зэрэг илүү өргөн хүрээг хамруулдгаас гадна орон сууц, нийтийн тээвэр, холбоо, нөхөн сэргээлтийн хэрэгсэл, хиймэл эрхтэн, рашаан сувиллын зардал зэргийг хөнгөлөх чиглэлийг түлхүү шийдвэрлэсэн байна.

Нийгмийн халамжийн хамрах хүрээний харьцуулалтад хамрагдсан орон /Япон улс, Франц улс, БНСУ/-ууд ядуу амьдралтай өрх, хүүхдийн нийгмийн халамжийг чухалд үздэг байна. Япон, БНСУ-ын хуулиар нийгмийн халамжид хамрагдах шалгуур үзүүлэлтийг тогтоогоод түүнд хамрагдах өрх айл, иргэнийг өөрсдийн нь гаргасан хүсэлтийн дагуу хульд заагдсан шалгуурыг хангаж буй эсэхийг мэргэшсэн нийгмийн ажилтнууд нь тогтоож халамжийн үйлчилгээ үзүүлдэг байна. Японд нийт хүн амын 0,97%, БНХАУ-д нийт хүн амын 0,2 хүрэхгүй хувь нь нийгмийн халамжид хамрагддаг байна.

Монгол улсын хувьд 1995 онд анх Нийгмийн халамжийн багц хууль батлагдан нийгмийн халамжийн тогтолцооны үндэс суурийг тавьсан ба 1998, 2005 онд шинэчлэн найруулж гаргаснаас хойш хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж ерөнхий үзэл баримтлал нь хэвээр үлдсэн хэдий ч 2006 онд Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай, 2007 онд Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль батлагдаж мөрдөгдсөнөөр 2004 онд 23,1 тэрбум төгрөг байсан нийгмийн халамжийн зардал 2008 онд 218,6 тэрбум төгрөг болж, 9,5 дахин өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжид хамрагдагсдын тоо 2004 онд 358,7 мянган хүн байсан бол 2008 онд 1,6 саяд хүрч 4,45 дахин нэмэгдэж нийт хүн амын 70 шахам %-ийг эзэлж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээг эрхлэх байгууллагын хувьд ялгаатай тал ажиглагдаж байна. Нийгмийн халамжийн салбарын удирдлага, зохицуулалтын асуудлыг Засгийн газрын түвшинд эрүүл мэнд, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлдэг жишиг нийтлэг байна. Харин орон нутгийн түвшинд ОХУ, Франц, Англи, зэрэг орнуудад төвлөрсөн удирдлагын зарчим түлхүү хэрэгжиж байна. БНХАУ, БНСУ, Индонези, Япон, Алжир зэрэг орнуудад орон нутгийн захиргааны байгууллагууд нийгмийн халамжийн удирдлага, зохицуулалтын үүргийг гүйцэтгэж байна.

Япон, БНСУ, Швед зэрэг улсуудад олон нийтийн оролцоог чухалд үздэг байна. Манай улсад нийгмийн халамжийн үйлчилгээг төрөөс үндсэндээ дагнан хариуцдаг жишиг тогтоод байхад дэлхийн бусад улс орнуудад нийгмийн хөгжил өөрчлөлттэй уялдаж халамжийн ажлын зорилго чиглэл нь шинэчлэгдэж, үйлчилгээний албадын тоо нэмэгдэж, арга хэлбэр нь өөрчлөгдөж, либералчлах үйл явц эхэлж, төвлөрсөн үйлчилгээ, төвлөрсөн удирдлагаас татгалзаж, удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаа нь орон нутгийн байгууллага, иргэдийн сонголт руу шилжих хандлагатай болж байна.

2.3. Бусад орнуудын туршлага

1. Япон улсын төрийн нийгмийн халамжийн тогтолцоо

Япон улсад төрийн нийгмийн халамжийн тогтолцоо дор дурдсан хэлбэртэй байна:

1. Ядуу амьдралтай хүмүүст үзүүлэх төрийн халамж
2. Хүүхдийн тэтгэмж
3. Хөдөлмөрлөх чадваргүй хүмүүсийн нийгмийн халамж

1. Ядуу амьдралтай хүмүүст үзүүлэх төрийн халамж

Японд 1874 онд ядуу хүмүүст туслах тухай анхны эрх зүйн акт гарч, 1937 онд ядуучуудад туслах тухай анхны хууль батлагдаж байсан хэдий ч дайны дараахь үеэс л энэ нь төрийн халамжийн нэг хэсэг болон хөгжжээ. Ядуучуудад үзүүлэх халамжийн үйлчилгээний тухай хууль тогтоомжид дор дурдсан 4 зарчмыг баримталдаг байна.

- Төрийн халамжийг шаардлагатай хүмүүст нь хүргэнэ.
- Шашин шүтлэг, хүйс, нийгмийн гарал зэргийг харгалзахгүйгээр эдийн засгийн хүндрэлтэй бүх хүмүүс төрийн халамж хүртэх эрхтэй байна
- Эрүүл мэнд, соёл болон бусад талаар доод түвшинд амьдардаг хүмүүс төрийн халамж хүртэх эрхтэй.
- Төрийн халамжид бүх иргэдийн дэмжлэг, оролцоо чухал бөгөөд халамж хүсэгчдийн өөрсдийн хүчин чармайлт мөн адил чухал.

Өөрөөр хэлбэл нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай байгаа тухай өрх иргэдээс өргөдөл, хүсэлт гаргаж, түүнийг нарийвчлан шалгасны дараа амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой гэдэг шалгуурт нийцэж байгаа эсэхийг нь хэлэлцэж шийдвэрлэдэг байна. Төрийн халамжийн хүрээнд 7 төрлийн тусламж, дэмжлэгийг орлогын түвшин, хэрэгцээнээс нь хамруулан ялгавартай үзүүлдэг. Үүнд:

- амьжиргааг дэмжих
- орон байраар хангах
- боловсрол олоход нь дэмжлэг үзүүлэх
- эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх
- эхчүүдэд үзүүлэх тусламж
- мэргэжил олгох
- оршуулгын зардал ... зэрэг болно.

Дээр дурдсан халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ **орон нутгийн онцлог, амьжиргааны өртөг, түвшин** зэргээс хамаарч ялгавартай ханддаг.

2. Хүүхдийн тэтгэмж

Хүүхдийн тэтгэмжийн тухай хууль анх 1971 онд батлагдаж хэд хэдэн удаа нэмэлт өрчлөлт оруулан мөрдөж байна. Хүүхдийн нийгмийн хамгааллын хүрээнд хүүхдийн тэтгэмж, хүүхэд өсгөсний тэтгэмж, хүүхдийн халамжийн нэмэлт үйлчилгээ хамрагдана. Хүүхдийн тэтгэмжийг ердийн ба тусгай гэж ангилах бөгөөд ердийн тэтгэмжийг бага орлоготой өрхөд олгодог бол тусгай тэтгэмжийг компанид ажиллагчид болон төрийн албан хаагч нарт орлого харгалзахгүйгээр олгодог. Хүүхдийн тэтгэмжийн эх үүсвэрийг Засгийн газар, ажил олгогч, хот, тосгод, орон нутгийн байгууллага хамтарч бүрдүүлдэг байна.

Хүүхэд өсгөсний тэтгэмжийг өрх толгойлсон эхчүүд, асран хамгаалагчид өрхийн орлогын хэмжээ, хүүхдийн тооноос хамааруулж харилцан адилгүй хэмжээгээр мөнгөн хэлбэрээр олгодог. Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт мөнгөн тэтгэмж мөн олгоно. **Хүүхдийн халамжийн үйлчилгээнд** цэцэрлэгүүд, өдрийн үйлчилгээний төвүүд, хүүхэд түр саатуулах газар, гэрээр хүүхэд асрах үйлчилгээг хамруулдаг.

3. Хөдөлмөрлөх чадваргүй хүмүүсийн нийгмийн хамгаалал

Нийгмийн халамжийн үйлчилгээнд дор дурдсан 4 хүрээний хөдөлмөрийн чадваргүй тахир дутуу хүсүүсийг хамруулдаг. Үүнд:

- Бие эрхтэний хүндрэлтэй тахир дутуу хүмүүс

- Сэтгэцийн хүндрэлтэй хүмүүс
- Оюун ухааны хомсдолтой хүмүүс
- Тахир дутуу хүүхэд

Бие эрхтэний хүндрэлтэй тахир дутуу хүмүүсийн нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн, төрөлжсөн, мэргэжлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ гэж ангилдаг. Тахир дутуу хүмүүсийг орлогын эрсдлээс хамгаалах хэрэгсэл нь үндэсний тэтгэврийн сан, ажиллагчдын тэтгэврийн даатгалын сан болон хүүхдийн тусгай тэтгэмжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмж бөгөөд эдгээр нь амьжиргааны доод түвшинг хангахгүй бол төрийн халамжийн хөрөнгөөс дараахь тусламж, тэтгэмжийг олгодог.

- Тахир дутуугийн тусгай тэтгэмжийг гэртээ амьдардаг 20 нас хүрсэн тусгай үйлчилгээ шаардлагатай иргэдэд олгоно.
- Тахир дутуу хүүхдийн хамгааллын тусламжийг тусгай асаргаа, халамж шаардлагатай тахир дутуу хүүхдээ гэртээ асарч байгаа өрхөд олгоно.
- Тахир дутуу хүүхэдтэй өрхийн тэтгэмжийг ийм хүүхэдтэй боловч тахир дутуугийн тэтгэвэр авдаггүй өрхөд олгоно.

Японы нийгмийн халамжийн удирдлага зохион байгууллалт

Нийгмийн халамжийн нэгдсэн удирдлага, зохицуулалтыг Засгийн газар, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам гүйцэтгэнэ. Нийгмийн хамгааллын төв зөвлөл, Тахир дутуу иргэдийн зөвлөл, Хүүхдийн хамгааллын зөвлөл энэ салбарын удирдлага, зохицуулалтад чухал үүрэгтэй оролцдог байна. Харин орон нутагт муж, хотын захиргаад, түүний нийгмийн хамгааллын хэлтэс, секторууд удирдлага зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг. Нийгмийн халамжийн системд нийгмийн ажилтны гүйцэтгэх үүрэг чухал байр суурийг эзэлдэг. Энэ салбарт ЭМНХЯамнаас зохион байгуулдаг тусгай сургалт, тусгай хөтөлбөрөөр зохион байгуулдаг бэлтгэл сургалтад хамрагдаж тодорхой нөхцөл болзлыг хангасан, үндэсний хэмжээнд явагддаг онцгой шалгуураар итгэмжлэл авсан,

“Итгэмжлэгдсэн нийгмийн хамгаалын ажилтан” гэрчилгээтэй мэргэжил, боловсролын тодорхой түвшинг хангасан ажилтнуудыг шалгаруулж ажиллуулах журамтай. Нийгмийн ажилтныг нийгмийн ажлын мэргэжилтэн, нийгмийн үйлчилгээний ажилтан гэсэн хоёр түвшинд авч үзэх бөгөөд “Нийгмийн итгэмжлэгдсэн ажилтан”-ы шалгаруулалтад орохын өмнө хамрагдсан байвал зохих сургалт, төгссөн байвал зохих сургууль, эзэмшсэн байвал зохих мэргэжлийг нэг бүрчлэн заасан шалгууртай байдаг байна.

2. Францын нийгмийн халамжийн тогтолцоо

1922 онд гэр бүлийн тусламжийн тухай анхы хууль батлагдсан бол одоо 1946 онд батлагдсан нийгмийн халамжийн тухай хууль үйлчилж байна. Францад нийгмийн халамжийн асуудлыг эв нэгдлийн систем, ерөнхий тусламжийн системийн хөлөлбөрүүдээр дэмжиж хэрэгжүүлдэг. Ерөнхий тусламжийн системд 13 төрлийн тусламж, тэтгэмжийг багтаадаг.

- Өрхийн тусламжийг доод цалингийн 55%-иас доош орлоготой хоёр хүүхэдтэй өрхөд олгоно.
- Бага насны хүүхдийн тэтгэмжийг өрхийн орлогын хэмжээг харгалзан 15 сараас 3 нас хүртэл олгоно.
- Гэр бүлийн нэмэгдэл тэтгэмжийг бага орлоготой 3-21 насны 3 ба Түүнээс дээш хүүхэдтэй өрхөд олгоно.
- Орон байрны тусламжийг 21 хүртэл насны насны олон хүүхэдтэй өрхөд орлогын хэмжээг харгалзан түрээсийн төлбөрийг нь төлөх, барьцаанд баталгаа гаргах хэлбэрээр үзүүлдэг.

- Өрх толгойлсон эмэгтэйн тусламжийг хүүхдээ асрах халамжлахад зориулж, ажилтай буюу жирэмсэн эмэгтэйд орлогоос хамааруулж тодорхой хугацаанд олгоно.
- Гэр бүлийн дэмжлэгийн тэтгэлгийг тодорхой нөхцлөөр бусдын дэмжлэггүйгээр хүүхдээ өсгөж байгаа эцэг, эх буюу хүүхэд өсгөж байгаа гуравдагч этгээдэд олгоно.
- Хүүхэд үрчлэн авсны тэтгэмжийг хүүхэд үрчлэн авсан гэр бүлд орлогын байдлаас нь хамааруулж олгоно.
- Гэрээр хүүхэд асрах тэтгэлгийг бага насны хүүхдээ гэртээ хөлс төлж бусдаар асруулдаг хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд олгоно.
- Хүүхэд өсгөсний тэтгэмжийг ажил хийхгүй байгаа эсвэл 2-оос дээш хүүхэд өсгөж байгаа Сүүлийн 5 жилийн хугацаанд 2-оос доошгүй жил ажилласан гэр бүлд хүүхдийг нь 3 нас хүртэл олгоно.
- Итгэмжлэгдсэн байгууллагаар хүүхдээ асруулах тэтгэлгийг эцэг, эх нь хөдөлмөр эрхэлдэг, хүүхдээ итгэмжлэгдсэн байгууллагаар асруулж байгаа 6 хүртэл насны хүүхдэд олгоно.
- Тусгай тэтгэмжийг тахир дутуу хүүхдийг халамжлахад олгодог.
- Сургуулийн жилийн тэтгэлгийг эцэг, эхийн орлогын хэмжээг харгалзан 6-18 насны хүүхдэд олгоно.
- Хүүхдээ асардаг эцэг, эхийн тэтгэмжийг хүнд өвчтэй, осолд орсон болон тахир дутуу хүүхдээ асардаг бүтэн ба хорогдуулсан цагаар тасралтгүй хөдөлмөр эрхэлдэг эцэг эхчүүдэд олгоно.
- Эв санааны нэгдлийн тэтгэмж. Ерөнхий тусламжийн системээр дамжуулан олгох дээрх тэтгэмж, тусламжаас гадна эв санааны нэгдлийн тэтгэмжийг нийгмийн халамжийн төрөлд хамруулан авч үзэх боломжтой.

Сүүлийн 10 жилийн 5 жилд нь хөдөлмөр эрхэлж байсан боловч удаан хугацаанд ажил олж чадаагүй гэр бүлд сарын орлогоос нь хамааруулж олгоно. Дээр дурдснаас үзвэл францад гэр бүл, хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлыг нийгмийн халамжийн бодлогын анхаарлын төвд тавьж ач холбогдол өгдөг нь илэрхий байна. 1997 оноос ахмадуудад урт хугацааны халамж, асрамжийн үйлчилгээ, түүний дотор гэрээр нь үйлчлэх бодлогыг түлхүү баримталж байна.

Францын нийгмийн халамжийн удирдлага, зохион байгуулалт

Хөдөлмөр ба нийгмийн харилцааны яам нийгмийн халамжийн системийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг. Үндэсний гэр бүлийн тусламжийн сан нийгмийн халамжийн системийн асуудлыг зохицуулж, орон нутгийн салбар нь тэтгэмж, тэтгэлэг, тусламжийг олгох асуудлыг зохицуулдаг байна.

3. БНСУ -ын нийгмийн халамжийн тогтолцоо

Солонгосын нийгмийн халамжийн систем болох төрийн халамжийн үйлчилгээнд дараахь төрлийн үйлчилгээ багтдаг. Үүнд:

- Бага орлоготой хүмүүсийн халамж
- Эмчилгээний тусламж
- Харж хандах хүнгүй иргэдийн халамж, үйлчилгээ
- Өвчтөнд үзүүлэх тусламж

Бага орлоготой хүмүүсийн халамж нь өөрт нь үзүүлэх тусламж, гэрийн үйлчилгээ, орон байрны дэмжлэг туслалцаа, ажиллах чадварыг нь дэмжих үйл ажиллагааг багтаадаг.

Төрийн халамжийн үйлчилгээний анхан шатны нэгж нь иргэдтэй хамгийн ойр дөт байдаг, тэдэнтэй хамгийн түрүүнд харьцдаг засаг захиргааны бүтцэд үйл ажиллагаагаа явуулдаг нийгмийн ажилтан байдаг.

Нийгмийн халамжийн хамрах хүрээнд дараахь хүмүүс багтдаг. Үүнд:

- 18 нас хүрээгүй хүүхэд, 65 –аас дээш насны ахмадууд, жирэмсэн эхчүүд
- Хөдөлмөрийн чадвараа алдсан, бие эхртэний согогтой болон сэтгэцийн хомсдолтой, хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Ахмад настан, тахир дутуу иргэд болон хүүхдээ өдөр тутам асардаг хүнд амьдралтай хүмүүс
- Хүнд амьдралтай бие даан амьдрах чадваргүй иргэд

Дээр дурдсан иргэдэд мөнгөн тэтгэмж олгож, сүүлийн 15 жилд гэрийн үйлчилгээ үзүүлэх болсон байна Тэтгэмжид дараахь зардлууд багтдаг: Үүнд:

- Амьжиргааны суурь зардал—хоол хүнс,түлш, хувцас, зайлшгүй шаардлагатай бусад зүйл
- Эмнэлгийн үйлчилгээний зардал
- Ерөнхий боловсролын зардал
- Оршуулгын зардал

Солонгоын нийгмийн халамж нь бусад орны нэгэн адил ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүүхдийн халамжийн асуудлыг хамааруулдаг. Харин Солонгост өнчин хүүхдийг тусгайлсан асрамжийн газар т авахаас аль болох тагалзаж, төрөөс хүүхэд гэр бүлийн орчинд өсөж хөгжих ёстой гэсэн зарчмыг баримталдаг байна. Хүүхдийг гэр бүлтэйгээ хамт амьдрахад үзүүлэх дэмжлэг туслалцааг тэргүүн ээлжин тавьдаг онцлогтой.

БНСУ -ын нийгмийн халамжийн удирдлага, зохион байгуулалт

Нийгмийн халамжийн асуудлыг Засгийн газар, орон нутгийн түвшинд орон нутгийн захиргааны байгууллагууд шууд хариуцдаг байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний эрх зүйн орчны талаархи бусад орнуудын зохицуулалт /харьцуулалт/

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээний хамрах хүрээ	Судалгаанд хамрагдсан улс орнууд			
	Монгол	Япон	Франц	БНСУ
1. Нийгмийн халамжийн тэтгэвэр	+	+	+	+
а/ ахмад настны	+	+	+	+
б/ хөгжлийн бэрхшээлтэй иргэний	+	-	+	Нийгмийн халамжийн ажилтны гүйцэтгэж байгаа үүргийн гол хэсэг
в/ ерх толгойлсон эх/эцэг/-ийн	+	+	-	
г/ тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэл насны хүүхдийн				

2.Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	+	-	-	+
а/ ахмад настныг асарч буй иргэний	+	-	-	+
б/ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний	+	-	-	-
в/ бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний	+	-	-	-
г/ бүтэн өнчин, эцэг эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмчлүүлж байгаа, хорих газар ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхэд /Гэр бүлийн тухай хуулийн 25.5/ болон хүчирхийллийн улмаас бие мах бодийн хохирол хүлээж, хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний				
д/ -Ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний				
е/ жирэмсэн, хөхүүл эхчүүдийн				
3.Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тусламж	+	+	+	+
4.Хүүхдийн мөнгөн тэтгэмж	+	+	-	+
5/Шинэ гэр бүлийн мөнгөн тусламж	+	-	-	-
6.Шинэ төрсөн хүүхдийн мөнгөн тусламж	+	+	-	-
7.Алдарт эхийн мөнгөн тусламж	+	-	-	-
8..Бага насны хүүхдийн тэтгэмж	-	+	+	-
9.Олон нийтийн оролцлоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ а/амьдралын итгэл олгох сургалт б/орллогын эх үүсвэртэй болгоход зуучлах в/сэргээн засах үйлчилгээнд хамруулах г/түр байршуулан асрамжлах д/гэрийн халамжийн үйлчилгээнд хамруулах	+	+	Эв санааны нэгдлийн тэтгэм-жээр дамжуулж эдгээрийг хэрэгжүүл-дэг	+
	+	+		+
	+	+		+
	+	+		+
	+	-		+
10. Гэр бүлийн дэмжлэг	-	-	+	+
10. Тахир дутуу хүмүүсийн хөнгөлөлт	+	-	-	+
11.Ахмад настны хөнгөлөлт	+	-	-	+
12. Улсын болон хөдөлмөрийн баатар, Сүхбаатарын одон, алдарт эхийн одонгийн мөнгө	+	-	-	-

13. Цэргийн тэтгэвэр авагчдын нөхөн олговор	+	-	-	-
14.Алдар цолтой ахмадуудын нэмэгдэл	+	-	-	-
15.Хүүхдийн хөгжлийн мөнгөн тэтгэлэг	+	-	-	-
16.Ядуу өрх болон хүмүүсийн нийгмийн халамж	-	+	+	+
17.Боловсрол олгох үйлчилгээ		+	+	-
18.Мэргэжил эзэмшүүлэх үйлчилгээ	-	+	-	-
19.Гэрээр хүүхэд саатуулсаны	-	+		-
20.Орон байрны дэмжлэг	-	+	+	-
21.Хүүхэд үрчлэн авсны	-	-	+	-
22.Гэрээр хүүхэд асруулсаны	-	-	+	-
23.Хүүхэд өсгөсний тэтгэмж	-	-	+	-
24.Итгэмжлэгдсэн байгууллагаар хүүхдээ асруулсаны тэтгэмж	-	-	+	-
Нийгмийн халамжийн үйл ажиллагааг эрхлэх байгууллага	НХХЯам	Эрүүл мэнд хөдөлмөр хамгааллын яам, нийгмийн хамгааллын, тахир дутуу иргэдийн, хүүхдийн хамгааллын зөвлөлүүдтэй хамтарч улсын хэмжээнд, харин орон нутгийн түвшинд муж, хотын захиргааны ны нийгмийн хамгааллын хэлтэс секторууд удирдлага зохицуулал-тын үүргийг гүйцэтгэдэг	Хөдөлмөр ба нийгмийн харилцаа-ны яам, Үндэсний гэр бүлийн туслам-жийн сан түүний орон нутаг дахь салбараар дамжуулж нийгмийн халам-жийн удирдлага зохицуу-лалтыг хэрэгжүүлдэг байна.	Засгийн газар орон нутгийн захиргаадаар дамжуулж нийгмийн халам-жийн удирдлага зохицуулалтын асуудлыг хэрэг-жүүлдэг байна.

**Гурав. Нийгмийн халамжийн харилцааг зохицуулж буй
эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагаа**

3.1. Нийгмийн халамжийн салбарын бодлогыг тодорхойлж буй баримт бичгүүд

1. Нийгмийн Халамжийн тухай хууль
2. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
3. Хөгжлийн бэршээлтэй иргэний хийгмийн хамгааллын тухай хууль
4. Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд , эх , гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль
5. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай хууль
6. Төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай хууль
7. Монгол улсын Засгийн газрын 162 -р тогтоол
8. Нийгмийн халамжийн сангийн дүрэм
9. Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм
10. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам
11. Ахмадын сан байгуулан ажиллуулах журам хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам, норм норматив г. м.

3.2. Нийгмийн халамжийн харилцааг зохицуулж буй Монгол улсын хуулиуд

Нийгмийн халамжийн чиглэлийн 3 хууль 2004 онд хэрэгжиж байсан бол өнөөдөр 6 төрлийн хууль хэрэгжиж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай
- Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай /2006 он/
- Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай /2007 он/
- Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай /2008 он/
- Сүүлийн жилүүдэд шинээр гарсан эдгээр хуулиуд хэрэгжсэнээр нийгмийн халамжид зарцуулах хөрөнгийн хэмжээ бараг 10 дахин, хамрагдах хүний тоо бараг 5 дахин нэмэгдсэн байна.

3.3. Нийгмийн халамжийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь өнгөрсөн хугацаанд ямар нэгэн төсөл хэрэгжүүлж байгаагүй Засгийн газрын 2008 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийн дагуу НХХЯ-ны дэргэдэх Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөрөөр дамжуулан 7 зорилтот хөтөлбөрийг зохион байгуулахаар ажиллаж эхлээд байна

* * *

Дөрөв. Нийгмийн халамжийн хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ

4.1. Нийгмийн халамжийн байгууллагын үнэлгээ, санал дүгнэлт

Монгол Улсын төрөөс иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах талаар авч хэрэгжүүлэх бодлогын томоохон шинэчлэл нь Нийгмийн халамжийн багц хуулиудад тусгалаа олсон байдаг. 1995 онд анх бие даасан Нийгмийн халамжийн тухай хууль батлагдан гарсанаас хойш зах зээлийн нийгмийн шаардлагаар энэхүү хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн 4 - 5 хууль бүхий Нийгмийн халамжийн багц хуулийг өнөөгийн нөхцөлд хэрэгжүүлж байна.

Нийгмийн халамжийн багц хуулийн үндсэн агуулга нь нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хагас бүтэн өнчин хүүхэд, 0-18 насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд мөнгөн тусламж үзүүлэх хэлбэрээр илэрхийлэгдэж байна.

1. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар энэхүү хуулийн 5.1.1, 5.1.4, 5.1.8-д заасан хөнгөлөлт үйлчилгээг эдлэхэд чирэгдэл учирдаг. Түүнчлэн тэжээн тэтгэх үр хүүхэдгүй ганц бие ахмад настны амьжиргаанд хуулийн 5.1.3 дахь заалт чухал шаардлагатай дэмжлэг боловч тийм ахмадууд харьцангуй цөөн байдаг. Үр хүүхэд нь тэжээн тэтгэх чадваргүй, хүнд нөхцөлд амьдарч байгаа ахмадууд нийгмийн халамжийн үйлчилгээний гадна үлдэх явдал байсаар байна. Харин амьжиргааны боломжийн нөхцөлд амьдарч буй ахмад дайчид, алдар цолтой ахмадууд нийгмийн халамжийн давхардсан үйлчилгээнд хамрагдаж авч буй мөнгөн тусламжийн хэмжээ нь харьцангуй өндөр байдаг.
2. Ахмад настны нийгмийн хамгааллын талаар цаашид анхаарах асуудал нь ахмадуудын нийгмийн халамжийн үйлчилгээг онож тогтоох шуурхай болгох явдал юм. Нийт ахмад настныг нийгмийн халамжид хамруулахгүйгээр зөвхөн амьжиргааны хүнд нөхцөлд байгаа өөрийгөө халамжлах чадваргүй, бага орлоготой ядуу өрхийн, архаг өвчтэй, үр хүүхэд нь асрамжлах чадваргүй ахмад настангуудыг хамруулж, тусламж дэмжлэгийг амьдралын наад захын эрэлт хэрэгцээг хангахуйцаар үзүүлэх шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хувьд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх нь тэдний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс ихэвчлэн шалтгаалж байна.
3. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, саажилттай болон сэтгэцийн өөрчлөлтэй хүнд хэлбэрийн бусдын асрамжлалгүйгээр бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох халамжийн үйлчилгээний хэмжээ нэр төрлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ нь адилхан тогтоогдсон боловч дотор эрхтний өвчлөлтэй хөнгөн хэлбэрийн ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харьцуулахад дээрх хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд маш хүнд нөхцөлд амьдарч байна. Гэсэн атлаа нийгмийн халамжийн үйлчилгээг хуулийн адилхан үйлчлэлээр авч байна.
4. Байнгын асаргаанд байдаг хэвтрийн өвчтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж, эмчилгээ шаардлагатай, эмнэлгийн байгууллагын хяналтанд байдаг иргэнд олгож буй мөнгөн тусламжийн хэмжээг зах зээлийн нөхцөлтэй уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай.
5. Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байхаар шинэчлэн тогтоох хэрэгтэй байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагчид нь харьцангуй цөөхөн бөгөөд хамгийн эмзэг эрсдэлтэй бүлгийн хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэд байдаг. Одоо авч буй тэтгэврийн хэмжээ нь 41000 төгрөг байна.

6. Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь олон хүүхэдтэй, орлого багатай өрхүүдийн амьжиргааны гол эх үүсвэр болж тухайн ядуу өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. "Хүүхэд хөгжил" улирлын мөнгөн тусламж, хүүхдийн сар бүрийн мөнгөн тэтгэмжийг нэгтгэн нэг эх үүсвэрээс олгох нь зүйтэй байна.
7. Жирэмсэн хөхүүл хүүхэлтэй эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмжийг амьжиргааны түвшингээр олгож, мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.
8. Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, бүтэц орон тоог оновчтой болгох хэрэгтэй байна. Аймаг дүүргийн хэлтсүүдийн орон тоог хүн амын тоо, үйлчилгээний ачаалал зэргээс шалтгаалан тогтоож, нэг мэргэжилтний үйлчилгээ үзүүлэх үйлчлүүлэгчийн тоо, норм нормативыг судалгаа шинжилгээний үндсэн дээр тогтоох нь зүйтэй байна

4.2. Төрийн бус байгууллагуудын үнэлгээ, санал дүгнэлт

Нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг хэлбэр болох хүнсний цахим талонд хамрагдах зорилтот иргэний эдийн засаг, нийгмийн байдлыг баталгаажуулах зорилгоор НХХЯ, түүний дэргэд ажиллаж байгаа АХБ -ны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөрийн нэгжийн захиалгаар "Зориг сан" -гаас нийслэлийн дүүргүүдэд явуулсан судалгаагаар хүн амын 0,39 – 1,92% нь хүнсний цахим талонд хамрагдахаар дүүргүүдээс тодорхойлсон байна.

Дүүргийн нийт хүн амын тоог хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоотой харьцуулсан нь

Багц	Дүүрэг	Нийт хүн ам (мян)	Хамрагдах иргэдийн тоо	Нийт хүн амд эзлэх хувь
Улаанбаатар - 1	Баянзүрх	235192	932	0.39%
	Багануур	25877	407	1.57%
	Багахангай	3742	56	1.49%
	Налайх	29115	561	1.92%
	Сонгинохайрхан	232326	2566	1.10%
Нийт	5		4592	

Энэхүү судалгаанаас харахад нийгмийн халамжийн зорилтот мөнгөн тэтгэмж, болон нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд зайлшгүй хамрагдах иргэдийн тоо нийт хүн амд бусад орнуудын нэгэн адил багаахан хувийг эзлэхээр байгаа нь тодорхой байна.




Тав. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн шинжилгээ

5.1. Улсын төсвийн нийт зардалд халамжийн зардлын эзэлж буй хувийн динамик судалгаа

Зарлагын нэр	Төсвийн зарлага /сая төгрөгөөр/							
	2005 он		2006 он		2007 он		2008 он	
	Сая төг.	Өмнөх оныхтой харьцуулсан %	Сая төг.	2005 оныхоос өссөн %	Сая төг.	2006 оныхоос өссөн %	Сая төг.	2007 оныхоос өссөн %
Улсын нэгдсэн төсөв	764.597	1,6	1237008,0	61,7	1747310,5	41,3	2466800,0	41,2
Нийгмийн халамжийн төсөв	23634,8		74783,6	3,2 дахин	205139,9	2,7 дахин	212994,7	3,0

Энэхүү хүснэгтэд авсан тоон үзүүлэлтүүдийг Сангийн яамнаас жил бүр гаргадаг Монгол улсын Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2005 - 2008 он/ -ийн эмхтгэл, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас албан ёсоор ирүүлсэн мэдээнээс авав



Дээрхи хүснэгт, диаграммаас харвал 2006 онд Улсын төсвийн зарлага 2005 оныхоос 61,7 % өссөн байхад нийгмийн халамжийн зардал 3,2 дахин, 2008 онд Улсын төсвийн зарлага 2007 оныхоос 41,3%-иар өссөн байхад нийгмийн халамжийн зардал 3,0%-иар өссөн байгаа нь нийгмийн халамжийн бодлого бүхэлдээ алдагдсан байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого зарлагын судалгаа
/2005 - 2008 оны байдлаар сая төгрөгөөр/

№	Он	Орлого	Зарцуулалт	
			Хамрагдсан хүн	Хөрөнгө
1	2005	3873.3	142230	3247.1
2	2006	6520.6	169863	4251.3
3	2007	11040.1	231660	10928.7
4	2008	16176.5	226414	15303.6
	Бүгд	37610.5	770167	33730.7

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого зарлагын тайланг авч үзэхэд: 2005 онд хамрагдсан хүний тоо 142230 зарцуулсан мөнгө 3247.1 байсан бол 2008 онд хамрагдсан хүний тоо 226414 зарцуулсан мөнгө 15303.6 болж өссөн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогод ахиц өөрчлөлт байгааг харуулж байна.

5.3. Нийгмийн халамжийн сангаас олгосон халамж үйлчилгээний судалгаа
Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт* /2005-2008 оны байдлаар/

№	Үзүүлэлт	2005		2006		2007		2008	
		х/тоо	дүн	х/тоо	дүн	х/тоо	дүн	х/тоо	дүн
1	Халамжийн тэтгэвэр	44680	7.699.699	45449	12.024.243.2	47820	15.742.404.0	51245	22.520.230.9
2	Халамжийн тэтгэмж	107257	10.162.482	110393	9.939.926.9	110724	15.789.391.3	108797	19.525.414.4
	Жирэмсэн эхчүүдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж			20218	901.167.6	77455	12.732.884.7		
	Жирэмсэн хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж							91225	15.753.607.9

	ахмад настны нөхцөлт мөнгөн тэтгэмж			1146	57.190.7	4326	579.024.8	7881	1.559.220.5
	ХБ-тэй иргэний нөхцөлт мөнгөн тэтгэмж			2973	199.114.9	6278	924.008.4	8695	2.036.181.9
	Жирэмсэн ба амаржсаны тэтгэмж	45554	4.134.861	37905	2.956.091.0				
	Хүүхэд асарсаны тэтгэмж	53917	5.736.883	44349	5.645.484.9	22289	1.484.587.5		
	Нярайн арчилгааны тэтгэмж	6736	165.983	3300	82.645.3				
	Ихэр хүүхдийн тэтгэмж	355	12.561	150	5.784.8				
	БӨХҮАӨ сгөсний тэтгэмж	695	112.174	402	92.447.7	375	68.885.9	885	155.452.2
	Хүүхэд ахмад настан, ХБИ -г гэр бүлдээ асарсан							111	20.951.9
3	Нөхцөлт мөнгөн тусламж							20342	3.190.973.3
4	Хүүхдийн мөнгөн тэтгэмж			872392	26.249.358.0	948713	33.223.089.9	942709	32.761.193.6

5	Шинэ гэр бүлд олгосон мөнгөн тусламж			23628	11.614.000.0	59448	29.724.000.0	34894	17.447.000.0
6	Шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж			41110	4.111.000.0	0.57693	5.769.300.0	63815	6.381.500.0
7	Алдарт эхийн одонгийн тусламж 1-р одон			28796	2.865.100.0	39272	3.920.375.0	37559	3.746.009.9
8	Алдарт эхийн одонгийн тусламж 2-р одон			40900	2.043.391.3	92424	4.576.546.9	95288	4.670.687.0
9	ОНОТ Халамжийн үйлчилгээ			6314	365.297.2	7611	599.936.3	25497	974.306.1
	Амьдралын итгэл олгох сургалт					1322	9.630.0	13443	261.978.9
	-Орлогын эх үүсвэртэй болгоход зуучлах					269	14.889.2	5444	199.364.6
	-Сэргээн засах үйлчилгээнд хамруулах					482	67.405.7	3250	172.312.6
	-Түр байршуулан асрамжлах					2665	91.153.6	1140	41.693.0
	-Гэрийн халамжийн үйлчилгээнд хамруулах					2673	416.857.8	2220	299.057.0
11	Халамж болон асрамжийн үйлчилгээ	27685	724.680	19605	755.409.4				

12	ТД Хүмүүст үзүүлсэн хөнгөлөлт	22413	1.419.076	25322	1.430.700.9	21970	1.396.640.3	60987	3.364.241.6
13	Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	111461	3.017.220	104137	2.666.497.2	113073	2.690.189.6	166616	6.214.795.0
14	Партизан у/баатарт үзүүлсэн хөнгөлөлт	682	42.598	6142	482.161.0	6458	764.900.0	7550	1,064,408.4
15	Улс ба хөдөлмөрийн баатар, СБаатарын одон, алдарт эх	1407	31,460		35,380.0		32,440.0		
16	Ахмад дайчдын нэг удаагийн тусламж		535,769						
17	Цэргийн тэтгэвэр							4992	4,992,612.8
18	Алдар цолтой ахмадуудын нэмэгдлийн тухай хууль							1062	853,951.7
19	Оршуулгын тэтгэмж	22	1,861	11	1,224.8				
20	Хүүхдийн хөгжлийн мөнгө					94948713	90,910,677.4	942709	89,958,068.2
	ДҮН	315585	23,634,843.0	1324199	74,783,689.9	242453919	205,139,890.7	2468774	212,994,705.8

Хөдөлмөр нийгмийн халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн судалгаа

* * *

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь 2005 онд байгуулагдаж 2005-2008 оны сангийн зарцуулалтын тайланг хянаж үзэхэд: нийт 2005 онд зарцуулалт 23,634,843.0 байсан бол 2008 онд 212,994,705.8 болж бараг 10 дахин өссөн харагдаж байна. Эндээс үзэхэд, 2004 онд намууд сонгуульд өрсөлдөхдөө амласан хүүхдийн мөнгө, шинээр гэр бүл бологсдод олгох мөнгө 70 шахам хувийг эзэлж байна.

Зургаа. “Нийгмийн халамжийн хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” судалгааны санал, дүгнэлт, зөвлөмж

Нийгмийн халамжийн хуулиудийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт, нийгмийн халамжийн байгууллага, бусад судалгааны байгууллагаас хийсэн судалгааны баримт бичигт тулгуурлан дор дурьдсан санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамжийн үйлчилгээ нь зөвхөн нийгмийн халамжийн хуулиудаар тогтоосон зорилтот иргэнд зориулагдсан хөрөнгө байх бөгөөд үүнийг улсын төсвөөс нэг мөр санхүүжүүлж байх нь зүйтэй болов уу.
2. Зарим орны жишгээр /шинээр мэндэлсэн хүүхэд, нийгмийн даатгалд хамрагдаагүй эхчүүдэд, жирэмсний болон тодорхой хугацаанд хүүхдээ асарсан г. м./ -ийн тэтгэмж олгох боломжтой. Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт тэтгэмж олгохыг тодорхой хугацаанаас эхлэн хүүхэд бүрт олгодог нэг удаагийн тэтгэмж гэж нэрлэх бололцоотой юм. Харин эх үүсвэр нь “Хүний хөгжлийн сан” байж болох юм.
3. Сүүлийн жилүүдэд шинээр бий болгосон хүүхдийн тэтгэмж, хүүхдийн хөгжлийн тэтгэмж шинэ гэр бүлийн мөнгөн тусламж зэрэг нийтийг хамарсан тэтгэмжээс татгалзах эсвэл боломжтой гэж үзвэл шинээр байгуулж байгаа “Хүний хөгжлийн сан”-гаас тусгайд нь санхүүжүүлж болох юм.
4. Нийгмийн халамжийн удирдлага зохицуулалтын үүргийг босоо тогтолцоогоор бус орон нутгийн эрх барих байгууллагад шилжүүлж, тухайлбал баг хорооны түвшинд засаг даргад нь шууд хариуцуулах юм бол энэ үйлчилгээ эзэндээ ойртох, баг хорооны дарга нь иргэддээ ойртох хөшүүрэг болно гэдэг нь Япон, БНСУ-ын туршлагаас тодорхой байна.
5. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкнаас гаргасан “Монгол улс дахь ядуурлын дүр төрх” судалгааны мэдээллээс дүгнэж үзэхэд нийт ядуу хүмүүсийн дунд ажил эрхэлдэг хүмүүс 66.2 хувийг эзэлж байгаа нь манай халамжийн үйлчилгээг хавтгайруулахад хүргэсэн гэж дүгнэх боломжтой. Ийм учраас цалин хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх замаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн доод хэмжээг нэмэгдүүлэх нь оновчтой болов уу. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн хэмжээг ч нэмэгдүүлэх шаардлагатай болох нь дээр дурьдсан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санал, “Монгол улс дахь ядуурлын дүр төрх” судалгаанаас илэрхий байна.
6. Нийгмийн халамжийн мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, тэдгээрийг энэ ажилд шалгаруулж авах талаар тусгай дүрэм, журам гаргах шаардлагатай болсон гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бодлогын баримт бичиг, судалгаа

1. “Нийгмийн халамжийг сайжруулах нь” Үндэсний семинар, 1993
2. ОУХБайгууллагаас Монгол улсын нийгмийн хангамжийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх талаар гаргасан илтгэл 1992 он
3. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг

4. Төрөөс тэтгэврийн тогтолцоог шинэчлэх талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл
5. Нийгмийн хамгаалал онол-арга зүй туршлага, харьцуулалат 2004 он
6. Дэлхийн банк Үндэсний статистикийн хорооны хамтарсан “Монгол улс дахь ядуурлын дүр төрх

Ном, гарын авлага

1. Ч.Дагвадорж. Нийгмийн хамгаалал: онол-аргазүй, туршлага, харьцуулалт УБ. 2004 он
2. П.Бямбацэрэн, Ч.Дагвадорж. Нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд. УБ. 2000 он

Хууль, эрх зүйн баримт бичиг

1. Монгол улсын үндсэн хууль
2. Нийгмийн халамжийн тухай хууль 2005 он.
3. Монгол улсыг хөгжүүлэх сангийн тухай хууль 2007 он.
4. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль 2005 он.
6. Эх хүүхдэд тэтгэмж олгох, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль 2006 он.
7. Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавъяат цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн тухай хууль 2008 он.

Электрон мэдээллийн эх сурвалж.

1. Yandex.ru – ОХУ
2. Parliament.kz- Казахстан улс
3. WWW.Government.kz
4. WWW.Pravo.by – БНБел Улс
5. Tusuv.mn



UIH.MN
СУДАЛГААНЫ САН